



НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДИЙН ГАЗРЫН АЛБАДАД ЗӨВЛӨН
ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Нийслэлийн Газрын алба, дүүргүүдийн Газрын албадын үйл ажиллагаанд Газрын тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, “Төрийн хяналт шалгалтын” тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр. Хамрагдах байгууллага, бүрэлдэхүүн, хугацаа:

Зөвлөн туслах үйлчилгээнд Нийслэлийн Газрын алба, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Налайх дүргүүдийн газрын албууд хамрагдах бөгөөд байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын ахлах байцаагч Ч.Энхчимэг, байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Э.Балжинням нар 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэнэ.

Гурав. Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдах асуудлууд:

Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын баталсан 2.10 кодтой “Газар олголтыг шалгах хяналтын хуудас” -аар эрсдэлийг тодорхойлон үнэлж, “Шилэн хяналт”-ын цахим мэдээллийн санд бүртгэнэ.

Мөн эрсдэлийг бууруулах талаар дотоод хяналт тавих, эрсдэлийг хэрхэн тооцох, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, хэрхэн арилгахад хууль эрх зүйн болон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналтын хуудсыг сурталчилна.

Түүнчлэн байгууллагын албан хаагчдаас мэргэшлийн мэдлэгийн сорил авч сургалт зохион байгуулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.

Дөрөв. Үр дүнг тайлагнах:

Зөвлөн туслах үйлчилгээний дүнг Нийслэлийн Газрын алба, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Налайх дүргүүдийн газрын албадын удирдлага болон холбогдох албан тушаалтанд танилцуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн зөвлөмж боловсруулан хүргүүлнэ.

Зөвлөн туслах үйлчилгээний хүрээнд хийгдсэн ажлын нэгдсэн дүнг удирдлагуудад танилцуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчилна.

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, ГЕОЛОГИ,
УУЛ УУРХАЙН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Д.БАТ-ӨЛЗИЙ

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ХЯНАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ



Ч.ЭНХЧИМЭГ